

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 10 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 10-р сард 2 удаа хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцлээ. Үүнд:

1. Орон нутгийн өмчит байгууллагуудыг өөрчлөн байгуулах тухай
2. Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай /Эргэлтийн эмийн сан/
3. Ойн тэмдэглэх тухай
4. "Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан" танилцуулах тухай
5. Төрийн дээд шагналд өргөн мэдүүлэх тухай
6. "Алтай орон сууцны корпораци" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байгуулах тухай

Хуульзүй дотоод хэргийн яамны Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны ахлах мэргэжилтэн М.Отгонжаргал, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Хууль бус худалдааны асуудал хариуцсан мэргэжилтэн С.Пүрэвсүрэн нар Говь-Алтай аймагт ажиллаж Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга, гишүүд, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн гишүүдтэй уулзалт зохион байгуулж ажлын чиглэл өгч ажиллалаа.

Мөн Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох шуурхай багийн үйл ажиллагаатай танилцаж, тус багийн ажиллах ажлын өрөө, шаардлагатай тохиолдолд ашиглах ажлын багаж хэрэгсэл зэрэг 55 сая төгрөгний тоног төхөөрөмжийг гардуулж, нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.

“Анагаахын шинжлэх ухаан” олон улсын IV хурал Алтай хотноо 2019 оны 10 дугаар сарын 13-15-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. АШУҮИС-ийн Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь аймаг дахь Анагаах Ухааны сургуулиуд ерөнхий зохион байгуулагчаар ажиллаж, Говь-Алтай аймгийн ИТХ, ЗДТГ, БОАЖГ, Аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, УАУ төв хамтран энэхүү хурлыг зохион байгуулсан юм.

Тус хуралд АНУ, БНХАУ, ОХУ зэрэг гадаадын эрдэмтэн судлаачдын баг, АШУҮИС, Анагаах Ухааны хүрээлэн, Цөм лаборатори, АШУҮИС-ийн бүрэлдэхүүн болон салбар сургуулиуд болон Монгол Улсад Анагаахын болон Боловсрол судлалын чиглэлээр сургалт явуулдаг их дээд сургуулиудын академич, профессор, дэд профессор, доктор, багш, оюутан 400 гаруй судлаачдын, судалгаа шинжилгээний 140 бүтээлийг хэлэлцэн, ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААН сэтгүүлийн тусгай дугаар болон ABSTRACT BOOK гэсэн 2 бүтээлээр нийтийн хүртээл болгожээ.

Говь-Алтай аймгийн төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын түншлэлийн 20 жилийн ойн хүрээнд “Тогтвортой хөгжил-түншлэл”-ийн зөвлөлийн сургалтыг 10 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж байна.

“Түншлэгч талуудтай хамтран ажиллах нь” сэдвээр ГБХЗХГ, ЭМГ, ЦГ, ХХҮХ, ХХААГ, БОАЖГ, МСҮТ-өөс төлөөлөл оролцож илтгэл тавих бол Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн ЭТИС хөтөлбөрийн хэрэгжүүлж буй төслийн танилцуулга,

Олон талт хамтын ажиллагааг дээшлүүлэх, Түншлэлийн ач холбогдол, Түншлэлийн зарчим үнэт зүйл, Түншлэлийг тогтвортой хөгжүүлэхийн тулд юу хийх вэ? зэрэг сургалтууд явагдаж төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын нийт 70 орчим төлөөлөл оролцсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 190 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 23 дугаар тогтоолоор 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласантай холбоотойгоор жилийн ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлуудыг иргэд, хөдөлмөрчдөд таниулах зорилгоор тус аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу төрийн байгууллагууд 2019 онд хийсэн ажлаа иргэдэд сурталчилах, төрийн үйлчилгээг нэг дороос хүргэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх үүднээс “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүд нэгдсэн зохион байгуулалттайгаар 2019 оны 10-р сарын 22-ны өдөр, сумд 10 дугаар сарын 15-25-ны хооронд тус тэмдэглэн өнгөрүүлж нийт 56 байгууллага оролцлоо.

Аймгийн ИТХ-ын дарга Л.Батжаргал “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг нээж үг хэлэв.

Тус арга хэмжээний үеэр иргэдэд хүргэж байгаа төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг үнэлүүлж, түүнд дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлох зорилгоор иргэдээс 8 салбар чиглэлийн хүрээнд 45 асуулт бүхий санал асуулгын хуудсаар сэтгэл ханамжийн судалгаа авлаа.

Аймгийн төвийн албан байгууллагын дарга эрхлэгч нарын шуурхай зөвлөгөөн 10 дугар сард нийт 4 удаа хуралдаж, аймгийн нийгэм, эдийн засаг, бүтээн байгуулалттай холбоотой нийт 57 үүрэг даалгавар өгснөөс 64,8 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд тус шуурхайгаас сүүлийн 3 сарын хугацаанд өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын автомашинд наалт наах, хэрэглэж хэвшүүлэх тухай аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/503 дугаар захирамжийн дагуу наалт хэрэглэх тухай албан бичгийг төрийн болон орон нутгийн өмчит 69 байгууллагад хүргүүлж 2019.10.30-ны өдрийн байдлаар нийт 24 байгууллагын 50 автомашинд наалт олгоод байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 526 дугаар захирамжаар байгуулагдсан Солонго хорооллын 120 айлын орон сууцанд орох иргэдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, шаардлага хангасан иргэдэд мэдэгдэл хүргүүлэхээр ажиллаж байна.

2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан “- УИХ-ын болон Засгийн газрын тогтоолоор батлагдсан үндэсний хөтөлбөрүүдийн жагсаалтыг шинэчлэн, холбогдох байгууллагад карталж, e-office программын лавлах /файлын сан/-д байршуулж чиглэл өглөө.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын хэрэгжүүлэгч 7 агентлагийн мэргэжилтнүүдийн /Байгаль орчин, аялал жуулчлалын

газар, Биеийн тамир, спортын газар, Боловсрол, соёл, урлагийн газар, Орон нутгийн өмчийн газар, Санхүүгийн хяналт, аудитын алба, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар/ албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн хуралд танилцуулж батлах зөвшөөрөл авахад бэлэн боллоо.

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.7 дахь хэсгийн дагуу төрийн албаны ерөнхий шалгалтын бүртгэлийг www.csc.gov.mn цахим хаягаар 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлүүлж, 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл бүртгэлийг явуулж, Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд 2 компьютер байрлуулан иргэдийг цахимаар бүртгүүлэх боломжийг олгож ажиллалаа.

Шалгалтыг 11 сарын 11-ний өдөр улс орон даяар эхлүүлж 11 дүгээр сарын 25-ны хүртэл зохион байгуулна. Ерөнхий шалгалт зохион байгуулах аймаг дахь салбар комиссыг салбар зөвлөлийн 3 дугаар тогтоолоор 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгууллаа.

2019 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын бэлтгэл ажлыг хангаж шаардлагатай техник хэрэгсэл тоног, төхөөрөмжийг бэлтгэн 2019 оны 10 дугаар сарын 12-16 ны хооронд цэрэг татах, халах ажлыг зохион байгуулж ЗХЖШ-с өгсөн хяналтын тоог 100 хувь биелүүлж ажиллав.

2019 оны хоёрдугаар ээлжийн орон нутгаас татагдсан цэргийн албан хаагчдыг анги салбарт нь хүргэх /Баянхонгор, Өвөрхангай, УБ/ ЗХЖШ-т мэдээ тайланг хүргэх ажлыг зохион байгуулж гүйцэтгэлээ.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр 10 дугаар сард давхардсан тоогоор 22400-22500 иргэн төрийн үйлчилгээг авсан байна.

Тайлант хугацаанд иргэдээс бичгээр Засаг даргад 11 өргөдөл ирснээс 2 өргөдөл шийдэрлэгдэж 9 өргөдлийн хуулийн хугацаа болоогүй судлагдаж байна.

Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111 дугаарт 65 иргэн хандсан байна. Ирсэн өргөдөл, гомдлыг аймгийн төрийн байгууллагуудын нэгдсэн систем “E-Office” программаар шилжүүлэн хяналт тавин ажиллаж байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 85.6 хувьтай байна.

ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

“Авлигагүй нийгэмд иргэн бүрийн оролцоо” аяны хүрээнд Сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн, санхүүгийн албаны дарга нарт хууль, эрх зүйн мэдлэг олгох сургалтыг Хүнс хөдөө аж ахуйн газар, Шүүхийн тамгын газар, аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж нийт 36 төрийн албан хаагч хамрагдлаа.

Хууль зүй дотоод хэргийн яамны Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны ахлах мэргэжилтэн М.Отгонжаргал, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын хууль бус худалдааны асуудал хариуцсан мэргэжилтэн С.Пүрэвсүрэн нар Говь-Алтай аймагт 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр ажиллаж Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга, гишүүд, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Шуурхай баг”-ийн гишүүдтэй уулзалт зохион байгууллаа.

Энэ үеэр хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох шуурхай багийн үйл ажиллагаатай танилцаж, цагдаагийн газарт шуурхай багийн ажиллах ажлын өрөөг тохижуулан шаардлагатай тохиолдолд ашиглах 55 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг гардуулан өглөө.

“Архигүй-Алтайчууд” дэд хөтөлбөрийн хүрээнд “Архины хэрэглээ ба хор нөлөө”, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтуудаар 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр аймгийн Цагдаагийн газраас Говь-Алтай аймгийн мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүд болон 22 аж ахуйн нэгжийн эмч нарын төлөөлөлд сургалт, мэдээлэл хийлээ.

Аймгийн Цагдаагийн газраас аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Хүүхдийн эрхийн тухай, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтууд, “Дураа бишээ Дүрмээрээ” аяны талаар яриа, таниулга хийж, зөвлөмж, сэрэмжлүүлэг тараалаа. Сургалт мэдээлэлд 258 багш хамрагдлаа.

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг 2019 оны 10 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд Говь-Алтай аймагт ажиллалаа.

Ажлын хэсэг ажиллах хугацаандаа аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Ардын дуу бүжгийн Алтай чуулгад Нийтийн албан хаагчдад сургалт зохион байгууллаа.

Сургалтын зорилго нь авлигын эсрэг Авлигын эсрэг хууль тогтоомж, авлигын хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам, Эрүүгийн хуульд заасан Авлигын гэмт хэргийн талаар, ХАСХОМ гаргагч нарын гаргадаг нийтлэг зөрчил дутагдлын талаар хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, чадавхжуулах юм.

Тус сургалтад 200 гаруй албан тушаалтан хамрагдаж, цаашдаа төрийн үйлчилгээг хүнд сурталгүй хүргэх, хариуцсан ажил чиг үүргээ хууль тогтоомжийн хүрээнд шударгаар гүйцэтгэн ажиллах уриалгад нэгдлээ.

Мөн 2019 оны 10 дугаар сарын 26-ны өдөр иргэдтэй уулзалт хийж, Авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигын хор хөнөөл, Авлига, ашиг сонирхол, төрийн үйлчилгээний хүнд суртал, төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол мэдээлийг 110 утсанд мэдээлэх, нийтийн албан тушаалтны ХАСХОМ-той хэрхэн танилцах талаар мэдээлэл өгч, иргэдийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авч, газар дээр нь шийдвэрлэж ажиллалаа.

Тус өдөрлөг уулзалтад Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэгтэй хамтран аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс хамтран үйл ажиллагаагаа сурталчилан, иргэд олон нийтэд мэдээлэл зөвлөгөөг өгч ажиллалаа.

Тус уулзалт өдөрлөг арга хэмжээнд 250 гаруй иргэд хамрагдлаа.

Оюуны өмчийн газартай хамтран 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдөр “Оюуны өмчийн тухай ойлголт”, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль”, “Аж үйлдвэрийн өмчийн тухай ойлголт”, “Аж үйлдвэрийн өмчийн мэдүүлгийн системийн хайлт, ашиглалт”, “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, тулгамдаж буй асуудлууд сэдвээр төрийн албан хаагчид, аймгийн жижиг, дунд бизнес эрхлэгчид, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга, Засаг дарга, иргэд олон нийтийг хамруулсан сургалт зохион байгуулж нийт 60 гаруй төлөөлөл хамрагдлаа.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах өдөрлөг” сумдад зохион байгуулж байна.

Ажлын хэсэгт аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурал, ГХУСАЗЗ, Аймгийн ЗДТГазар, Прокурорын газар, Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Татварын хэлтэс, Эрүүл мэндийн газар хамтран ажиллаж байна.

Тус өдөрлөгийн үеэр иргэд, төрийн албан хаагчдад хууль тогтоомжийн талаар сургалт, мэдээллийг хийж, иргэдийн дунд хууль, эрх зүй, танин мэдэхүйн АХА

тэмцээнийг зохион байгуулж, Иргэдийг замын хөдөлгөөнд "Дураараа биш ээ Дүрмээрээ" оролцохыг уриалж ажиллаж байна.

Стандарт, Хэмжил зүйн газрын Үнэт металлын сорьцын хяналтын газрын даргын 2019 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 07/739 тоотын дагуу Говь-Алтай аймгийн хэмжээнд үнэт эдлэл худалдан борлуулж байгаа ААНБ, иргэдийн зарж борлуулж байгаа үнэт эдлэлд сорьцын баталгаажуулалт хийгдсэн эсэхийг шалгах, сорьцын баталгаажуулалтын талаар зөвлөгөө мэдээлэл өгөх ажлыг аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэгийн орон нутаг дахь орон тооны бус улсын байцаагч нар хамтран 2019 оны 10 дугаар сарын 01-02 –ны өдрүүдэд удирдамжийн дагуу зохион байгууллаа.

Шалгалтаар үнэт эдлэл худалдаалж байгаа газруудын 2 дэнсийг газар дээр нь баталгаажуулж, Мөнгөн аяга түүний шаардлага MNS 6505:2015 стандартын шаардлагын дагуу зарагдаж байгаа мөнгөн аягануудад хяналт тавьж, сорьц тогтоох шаардлагатай эдлэлүүдийг үнэт металлын сорьц тогтоох лабораторит шилжүүлж шалгуулах Улсын байцаагчийн албан шаардлагыг гардуулан өглөө.

Үйлдвэрлэгчид үнэт эдлэлийн орцны хэмжээг тавьдаггүй, үнэт эдлэлийн хэмжээний тодорхой мэдээллийг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс харах боломжгүй, хаана үйлдвэрлэсэн нь тодорхойгүй, шошгогүй мөнгөн аяганууд худалдаалж байсан зөрчил илэрсэн.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Орон нутгийн төсвийн нийт орлого 6009.8 сая төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 13.7 хувиар буюу 723.5 сая төгрөгөөр давж биелсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 19.3 хувиар буюу 970.9 сая төгрөгөөр их байна.

Төсвийн зарлага 45766.0 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 43104.0 сая төгрөгийн буюу 94.2 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Тусгай зориулалтын шилжүүлгээр 23993.7 сая төгрөг, улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр 10074.8 сая төгрөгийг тус тус хуваарийн дагуу бүрэн авч сум, байгууллагуудын дэмжлэгийг бүрэн олголоо.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээр 4408.4 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 3908,5 сая төгрөгийн санхүүжилт авч 88.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийгмийн халамжийн сангаас санхүүждэг онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжид 14 иргэнд 16,8 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилээний бүлгийн төсөлд 46 иргэнд 30,5 ая төгрөг нийт 60 иргэнд 47,3 сая төгрөг зарцууллаа.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Цэнгэлдэх хүрээлэнгийн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерт “Эл Эй Ай Ди групп” ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүлэв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжилт нь хийгдэх Цогт сумын Баянтоорой тосгоны спорт заалны барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “Мөнхтооройт” ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Хандивын хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Аймгийн аюулгүйн нөөцөд өвс бэлтгэн нийлүүлэх барааны нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт “Жаргалант

луу” ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Хантайширын нуруунд байгалийн түүхийн музей бүхий алсыг харах зориулалт бүхий цамхаг барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг дахин зарлалаа.

Гадаадын хөрөнгө оруулалтаар санхүүжилт нь хийгдэх Цогт суманд ухаалаг төхөөрөмж бүхий худгийн барилга барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “Баялаг говь” ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

НҮБ-ын хүүхдийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Тайшир суманд ухаалаг төхөөрөмж бүхий ундны усны худгийн барилгын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “Баялаг говь” ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

НҮБ-ын хүүхдийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Есөнбулаг сумын гэр хорооллын 4 багийн худгийн хайс хамгаалалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “Дөл-Өөдөө” ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Алтай хотын хатуу хучилттай авто зам дагуу тэмдэг, тэмдэглэгээ хийх ажлын тендерт Д.Болормаа ахлагчтай иргэдийн бүлэг шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Бүгд найрамдах Хятад ард улсын хандивын хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Аймгийн Засаг даргын Тамгын газарт автомашин нийлүүлэх барааны тендерийг дахин зарлалаа.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Хүүхдийн паркын тоглоомын тоог нэмэгдүүлэх /2 ширхэг/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт М.Одням ахлагчтай иргэдийн бүлэг шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүлэв.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Хүүхдийн паркын тоглоомын тоог нэмэгдүүлэх /2 ширхэг/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт Б.Дашрэнцэн ахлагчтай иргэдийн бүлэг шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүлэв.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх LED дэлгэц суурилуулах, тохижуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт гүйцэтгэгч шалгараагүй тул дахин зарлалаа.

НҮБ-ын хүүхдийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Баян-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн гадна ариун цэврийн байгууламж барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг дахин зарлалаа.

Гамшгийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Малчдад захиалгын дагуу 160 тонн өвс нийлүүлэх барааны тендерийг дахин зарлалаа.

НҮБ-ын хүүхдийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Есөнбулаг сумын 5 дугаар цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг дахин зарлалаа.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Нарлаг төвийн 5, 7 дугаар байрны дээврийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг дахин зарлалаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/469 дүгээр захирамжаар Чандмань, Эрдэнэ сумдад өмчийн бүртгэл хяналттай холбоотой хяналт шалгалтыг холбогдох албан хаагчидтай хамтран зохион байгууллаа.

ДӨРӨВ. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Засгийн газрын 285 дугаар тогтоолын хүрээнд аймгийн аюулгүй нөөцөд 160 тн өвс, 85.5 тн тэжээл бэлтгээд байна.

Тус аймагт 2019-2020 оны өвөл, хавар 18 сумын 87 багийн 7205 малчин өрхөд тэмээ 42.8 мянга, адуу 118.9 мянга, үхэр 81.8 мянга, хонь 986.6 мянга, ямаа 2054.5 мянга, бүгд 3580.3 мянган толгой, хонин толгойд шилжүүлснээр 4781.3 мянган толгой малыг өвөлжүүлэхээр бэлтгэл зохион байгуулалт хийсэн.

Дотоодын хэрэгцээ болон зах зээлд тэмээ 4.7 мянга, адуу 25.7 мянга, үхэр 17.5 мянга, хонь 306.5 мянга, ямаа 521.3 мянга, нийт 875.7 мянган толгой малыг борлуулах судалгаа гарсан.

Аймгийн бэлчээрийн дундаж ургац 0.2-2.9 ц/га байна. Бэлчээрийн даацыг нийт нутгаар тооцоолж гаргахад 14.5 хувь нь бэлчээрийн нөөцтэй, 11.8 хувь нь бэлчээр хүрэлцээтэй, 47.4 хувь нь даац 1-3 дахин хэтэрсэн, 11.8 хувь нь даац 3-5 дахин хэтэрсэн, 14.5 хувь нь даац олон дахин хэтэрсэн гэсэн дүгнэлт гарсан.

Аймгийн дүнгээр мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлыг 81,8 хувиар хангасан байна.

Газар тариалангийн чиглэлээр:

Ургац хураалтын эцсийн мэдээг нэгтгэн гаргаж, ХХААХҮЯамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлэв.

Тус аймаг нь 2019 онд нийт 1371 га-аас, 3955 тн ургац хураан авсан.

Үүнд: Үр тариа 178 га-аас 368 тн, төмс 100 га-аас 647 тн, хүнсний ногоо 71 га-аас 491 тн, ногоон тэжээл 837.5 га-аас 2376 тн, жимс жимсгэнэ 53 га-аас 73.5 тн-ыг тус тус хураан авсан байна.

Аймгийн Тариалан эрхлэлтийг дэмжих санд өртэй, шүүхийн захирамж нь гарсан боловч зээлээ эргэн төлөхгүй байгаа Есөнбулаг сумын иргэн Д.Цанлиг, Шарга сумын иргэн Д.Бямбатөгс нарын зээлийг төлүүлэхээр, шүүхийн гүйцэтгэх хуудас гаргуулан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт материалыг нь хүргүүлэн зээлийг эргэн төлүүлэх гэрээ хийв.

Солонгос улсаас техник дундын үйлчилгээний төв байгуулах хөрөнгө оруулалт татах техник эдийн засгийн үндэслэлийг боловсрууллаа. Тус аймгийн атаршсан тариалангийн талбайн судалгааг гарган ХХААХҮЯамны ГТБХЗГазарт хүргүүлэв.

Тус аймаг нийт 17 услалтын системийг түшиглэн газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх нийт 5121 га талбайтай. Үүнээс сүүлийн 5 жилд 1300 га-д тариалалт хийгдэж 3821 га-д нь тариалалт хийгдээгүй өөрөөр хэлбэл атаршсан газар бий болсон байна. Харин 80 орчим га-д булаг шанд түшиглэн тариалалт хийгддэг ба үүнээс 10 га тариалангийн талбай атаршсан бөгөөд аймгийн хэмжээнд нийт 3831 га тариалангийн талбай атаршсан.

Хүнс, худалдаа, ЖДҮ-ийн чиглэлээр:

Худалдаа үйлчилгээний зориулалт бүхий 60 ширхэг стендийг ашиглалтад хүлээж авав.

Жижиг дунд үйлвэрлэлийг хөгжүүлэх сангаас 13 иргэн 6 аж ахуйн нэгжид 815,0 сая төгрөгийн зээлийг олгоод байна.

Сумдын ахуйн үйлчилгээний болон халуун усны хангамжийн судалгааг нэгтгэж ХХААХҮ-ийн яаманд хүргүүллээ. Аймгийн хэмжээнд 28 халуун ус байгаагаас 20 нь байнгын ажиллагаатай байна. Шарга сумын төвд халуун усны насос хуучирч муудсан, халаалтын зардал хүрэлцдэггүй учир ажилладаггүй, сургуулийн халуун ус ажилладаг. Бугат сумын халуун ус тогтмол биш /сард 1 удаа/, Дэлгэр сумын халуун ус улирлын чанартай үйл ажиллагаагаа явуулдаг. Баян-Уул сумын халуун усны барилга байгууламж, тоног төхөөрөмж хуучирсан тул ажилладаггүй байна. Тус сум аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 40.0 сая төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 12.0 сая төгрөг, нийт 52.0 сая төгрөгөөр шинээр халуун ус барихаар зураг төсөв хийлгэсэн. 2020 оны 6 дугаар сард ашиглалтад оруулахаар төлөвлөж,

Дэлхийн Зөн ОУБ-ын Говь-Алтай ОНХ-тэй хамтран ажиллах боломж нөхцлийн талаар санал солилцох уулзалт зохион байгууллаа. Уулзалтын үр дүнд 2020 онд хамтран ажиллах гэрээ байгуулж, хийх ажлын төлөвлөгөө боловсруулахаар тохиролцсон.

“Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээний дүнг хэлэлцэн тайланг ХХААХҮ-ийн яаманд хүргүүллээ.

ТАВ. БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Чандмань сумын хилийн цэсийн маргааныг шийдвэрлүүлэхээр хүсэлт тавьсны дагуу Геодези, зураг зүй хариуцсан мэргэжилтэн Чандмань сумтай Баянхонгор аймгийн Баянцагаан, Баацагаан сум, Чандмань сумтай Эрдэнэ сумын хилийн цэсийн тодотголыг ГЗБГЗЗГ-с ирүүлсэн “Хилийн цэсийн маргаан шийдвэрлэх заавар”-ын дагуу шийдвэрлэлээ.

Улсын хэмжээнд газрын бодит үнэ цэнийг олон улсын жишгийн дагуу зах зээлийн зарчимд үндэслэн тогтоож, газрын суурь үнийг шинэчилж, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод болгох гэрээт ажлын хүрээнд хөгжүүлж байгаа Газрын төлбөр, татварын программыг 2020 оны 1 дүгээр сараас эхлэн улсын хэмжээнд нэвтрүүлэхээр ажиллаж сумдын 5 жилийн төлбөрийн судалгааг нэгтгэх ажлыг хийж байна.

Тус газар нь Газрын төлбөр, татварын программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхтэй холбоотойгоор 18 сумын газрын даамлыг программ дээр ажиллах болон өмнөх оны газрын төлбөрийн мэдээллийг нөхөн оруулах сургалтыг 09 сарын 23-10 сарын 28-ний хооронд зохион байгуулж программ хөгжүүлэлтийн ажил 70%-тай явагдаж байна.

Аймгийн 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 1 нэгж талбарт газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг дахин зарлах тухай, 2 нэгж талбарт газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зарлах захирамжуудыг газрын биржийн цахим системд бүртгэж олон нийтэд мэдээллээ.

Газрын төлбөрийн орлогод сарын хугацаанд 44 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Мөн “Мөнхтооройт” ХХК-аас ирүүлсэн далан барих ажлын хүрээнд газар чөлөөлүүлэх шаардлагатай 1 аж ахуйн нэгж 1 иргэнд газар чөлөөлөх хугацаатай мэдэгдэх хуудас хүргүүлж ажилласны дүнд газар чөлөөлүүлэхээр болсон.

Үерийн далангийн суваг хийгдэхээр төлөвлөсөн газарт хашаа хатгасан 2 иргэн, 2 ААН-д газар чөлөөлөх тухай хугацаатай мэдэгдэх хуудас хүргүүлсэн.

Газрын кадастрын зураг 4 иргэнд гаргаж өгч үйлчилсэн. Газар эзэмших эрхийн гэрчилгээ 3 иргэнд олгож, гэрээ байгуулсан.

Аймгийн засаг даргын 2019 оны А/439 дүгээр захирамжаар зарлагдсан 2 нэгж талбарын дуудлага худалдааг 2019 оны 10 сарын 09-ний өдөр зохион байгуулж худалдаа үйлчилгээний зориулалттай 150 м2 талбайг 1,8 сая төгрөгөөр газар эзэмших эрхийн гэрчилгээг эзэмшихээр болсон.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2019 оны 156 дугаар тушаалын дагуу “газар өмчлөх, эзэмших, ашиглах хүсэлт, хүсэлт хүлээн авах тухай тодорхойлолт, хариу өгөх мэдэгдэл, газар ашиглах тухай хүсэлт бүртгэх маягт, газар эзэмших эрх шилжүүлж авсанаар үүсэх эрх, үүргийг хүлээн зөвшөөрөх мэдэгдэл”-ийн зааврыг сумын даамлуудад хүргүүлэн ажиллалаа.

Газар эзэмшигч 12 иргэн, 2 төрийн байгууллагатай гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, 14 иргэний эрхийн гэрээний биелэлтэд хяналт тавьж, гэрээ дүгнэх ажлыг зохион байгуулж, 17 иргэнд газрын кадастрын зураг гарган үйлчиллээ.

Газар өмчлөх өргөдөл гаргасан 21 иргэний хүсэлтийг Газрын кадастрын мэдээллийн санд шүүлт хийж 16 иргэний кадастрын зургийг мэдээллийн санд оруулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газар эзэмшүүлэх нийт 7 захирамжаар олгосон 28 нэгж талбар газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулсан.

Газар эзэмшигч 10 иргэн, 5 төрийн байгууллагаас мэдүүлэг хүлээн авч кадастрын зураг, хаягийн тодорхойлолтыг гарган газар эзэмшүүлэх захирамжийн хамт цахим хэлбэрт оруулан Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамж ашиглан Улсын бүртгэлийн хэлтсийн дундын хур системээр илгээн газар эзэмших эрхийн улсын бүртгэлийн Э дугаар авсан.

Тус онд үүссэн хилийн цэсийн маргааны талаарх судалгааг гарган шийдвэрлэх боломжтой маргааныг газар дээр нь шийдвэрлэн судалгааг ирүүлэх талаархи албан бичгийг сумдад хүргүүлэн ажиллалаа.

ГЗБГЗЗГазар нь 2019 оны 10 сарын 03-ны өдрийн А/211 дугаар албан тушаалаар ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН ЗӨВЛӨЛ –ийг тус газрын дэргэд байгуулсан байна. Үүний дагуу Газар зүйн нэрийн аймаг дахь салбар зөвлөлийг байгуулах ажил зохион байгуулалтын үе шатанд явж байна. Мөн Газар зүйн нэрийн Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж УИХ, ЗГ-т танилцуулах, батлуулахаар газар зүйн шинэ нэр, өөрчилөгдсөн нэрийн талаархи асуудлыг боловсруулан ГЗБГЗЗГ-т хүргүүлэн ажилласан

Мөн газар нутаг усаа сайн мэддэг хүмүүсийг бэлтгэх ажлыг сумдын газрын даамлуудад даалган ажиллалаа.

2. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Солонго хорооллын гадна инженерийн шугам сүлжээний ажил, Үерийн далангийн ажил соёл амралтын хүрээлэнгийн багц-2 ажлын явцтай 10 сарын 08- 09-танилцан барилга байгууламжийн ажилд захилагчийн техник хяналтыг хийж гүйцэтгэсэн.

Алтай хотын 80 жилийн ойн хүрээнд хийгдэж буй Алтай хотын тохижилтын ажлын нэг хэсэг болох гэрэлтүүлгийн ажилтай 10сарын 6-8ны өдөр танилцсан.

Аймгийн шугам сүлжээний судалгааны материалын бүрдүүлэлт хийж Аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн.

ГХБХБГ-ын дарга, мэргэжилтэн 10 сарын 10-14-ны өдрүүдэд Бигэр, Эрдэнэ, Цогт, Чандмань сумдад ажиллаж, тус сумдад хэрэгжиж буй барилга угсралтын ажлуудад захиалагчийн техник хяналт гүйцэтгэлээ.

ГХБХБГ-ын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Төгрөг, Бугат, Тонхил, Дарив, Баян-Уул сумдад ажиллаж, тус сумдад хэрэгжиж буй барилга угсралтын ажлуудад захиалагчийн техник хяналт гүйцэтгэлээ.

Цогт сумын Эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч “Сод энх констракшн” ХХК ажлаа гүйцэтгэж дуусган улсын комисс ажиллуулах тухай албан тоот өгсний дагуу 2019 оны 10 сарын 10-ны өдөр улсын комисс ажиллан үүрэг даалгавар өгсөн.

Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын барилга угсралтын ажлын гүйцэтгэгч “Ашид гэгээн өргөө” ХХК ажлаа гүйцэтгэж дуусган улсын комисс ажиллуулах тухай албан тоот өгсний дагуу 2019 оны 10 сарын 10-ны өдөр улсын комисс ажиллан үүрэг даалгавар өгсөн.

Солонго орон сууцны хорооллын гадна шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчээр “Түм дэлгэрэх” ХХК ажиллаж, гадна шугам сүлжээний угсралтын ажил хийгдэж байна.

Аймгийн статистикийн хэлтэст 2019 онд хэрэгжиж буй барилга байгууламжийн мэдээллийг гарган хүргүүлэв.

Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлд аймгийн нийтийн аж ахуйн байгууллагууд болон шугам сүлжээний мэдээллийг гарган цахим хаягаар хүргүүллээ.

ГЗБГЗЗГ-т 2018, 2019 онд ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээлэл, 2019 онд ашиглалтад орох барилга байгууламжийн мэдээллийг гарган ГХБХБГ-ын 2019 оны 10 сарын 17-ны 467 дугаар албан бичгийг тус тус хүргүүллээ.

Аймгийн Статистикийн хэлтэст аймагт хэрэгжиж буй барилга байгууламжийн талаар шаардлагатай мэдээллийг гаргаж өгөв.

Барилгын хөгжлийн төвийн 2019 оны 10 сарын 18-ний 3/2923 албан бичгийн дагуу аймгийн цэвэрлэх байгууламж, сумдын гүний худаг, цооногийн хүчин чадлын талаар судалгааг гарган хүргүүлэв.

Т.Ууганжаргал ахлагчтай иргэдийн бүлгийн хийж гүйцэтгэсэн “Авто замын гэрлэн дохио”, “Цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлгийн ажлуудад 2019 оны 10 сарын 22-ны өдөр барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллан ашиглалтад хүлээн авлаа.

Улсын комисс ажилласан ажлуудын бичиг баримтын бүрдлийг хянаж, дутуу баримт бичгүүдийг бүрдүүлэх ажил хийгдлээ.

Албан газар болон айл өрхийн цэвэр болон бохир усны дуудлагын мэдээ

Манай байгууллага нь Алтай хотын ард иргэдийг аятай тухтай амьдруулах зорилгоор ажлын цагаар 70483656 дугаар, ажлын бус цагаар 99212073 дугаарын утсанд албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн цэвэр болон бохир усны яаралтай дуудлагын байнга хүлээн авдаг.

2019 оны 10-р сарын 30-ны өдрийн байдлаар

№	Дуудлагын төрөл	Албан байгууллага, ААН	Айл өрх	Нийт дуудлага	Дуудлага барагдуулалтын хувь
----------	------------------------	-------------------------------	----------------	----------------------	-------------------------------------

1	Цэвэр ус	48	12	60	100%
2	Бохир ус	29	17	46	100%
3	Гомдол	-	-		
Нийт		77	19	96	100%

Нийт цэвэр усны шугам сүлжээ, тоног төхөөрөмжтэй холбоотой нийт 77 дуудлага ирсэнээс албан байгууллага-48, айл өрхөөс-12, бохир усны шугам сүлжээ, тоноглолтой холбоотой 46, дуудлага ирсэнээс албан газар 29, айл өрхөөс 17 дуудлага тус тус ирсэн байсан. Дээрхи хугацаанд гомдол, санал ирээгүй байна. Дуудлага барагдуулалт 100%-тай байна.

ЗУРГАА. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

Ховд аймагт 10 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Монгол Улсын Засгийн газрын “Давсны хэрэглээг бууруулах” үндэсний стратеги, “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Дэлхийн хүнсний өдөр”-ийг тохиолдуулан ЭМЯ, НЭМҮТ, ХХААХҮЯ хамтран “Баруун бүсийн хүн амын давсны хэрэглээг бууруулахад төр, хувийн хэвшлийн байгууллагын оролцоо, дэмжлэг, хамтын ажиллагаа” сэдэвт шийдвэр гаргагчдын уулзалт-семинар”-т оролцож “Давсны хэрэглээг бууруулах Говь-Алтай аймгийн туршлага, цаашид авах арга хэмжээ”, “Давсны хэрэглээг бууруулах” үндэсний стратегийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ сэдэвт илтгэлүүдийг тус тус танилцууллаа.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгч Сергей Диордица, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын дарга Я.Буянжаргал тэргүүтэй ажлын хэсэг "Орон нутгийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх" чиглэлээр 10 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд манай аймагт ажиллаж байна.

Ажлын хэсэг 10 дугаар сарын 28-ны өдөр аймгийн удирдлагуудтай уулзалт хийж эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцлоо.

Түүнчлэн Төгрөг, Шарга сумдад 10 дугаар сарын 29-нд, Тайшир, Дэлгэр сумдад 10 дугаар сарын 30-ны өдрүүдэд ажиллалаа.

“Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөр, “Эрүүл хүүхэд –Алтайн ирээдүй” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, “Төрөлх Алтай” ТББ, “Малчдын эрүүл мэндийг дэмжих нийгэмлэг”-тэй хамтран 2019 оны 10 дугаар сарын 4-6 –ны өдрүүдэд хүүхдийн шүдний урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эмчилгээг зохион байгууллаа. Уг үзлэгийг Улаанбаатар хотын Их зайсан, Импайр, Голден тийт, Кроун мед, Халиун толгой, Дента сос шүдний эмнэлгийн эмч нарын баг ирж ажиллан, Есөнбулаг сумын сургуулиуд, АШУҮИС-ийн лицей, МСҮТ-ийн зорилтот бүлгийн 392

хүүхдийг үнэ төлбөргүй шүдний үзлэг, эмчилгээнд хамрууллаа. Үзлэгийн дүнд 306 хүүхдэд шүдний ломбо эмчилгээ хийн, эмчилгээ хийх боломжгүй болсон 150 шүд авч, хамгаалах түрхлэг түрхэн үнэ төлбөргүй тусламж үйлчилгээ үзүүллээ. Үзлэгт хамрагдсан 392 хүүхдээс цоо эрүүл шүдтэй 28 буюу 7,1% , сувгийн эмчилгээ шаардлагатай 63 хүүхэд буюу 16% -д нь зөвлөгөө өгч ажиллалаа.

Аймгийн хэмжээнд 2019 оны 3-р улиралд сумдад болон гэртээ эндсэн 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 4 тохиолдлын хэлэлцүүлгийг Эрүүл мэндийн газрын хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцэх комисс, сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн их эмч, эх баригч, сувилагч, лаборант нийт 51 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулан хэлэлцлээ.

“Сувилахуйн ур чадвар ба манлайл” сэдэвт 2 багц цагийн сургалтыг зохион байгуулж 19 сумдын эрүүл мэндийн төвийн 25 сувилагч тусгай мэргэжилтэн хамрагдлаа. Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран шинэ төгсөн ирсэн сувилагчийг ажлын байранд дадлагажуулах сургалтад сувилагчийг төрөх эмэгтэйчүүд, дотор, мэс засал, хүүхдийн тасагт 14 хоногоор сургаж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс хуралдаж 18 сумын эмийн сангийн төслийг эхний шатанд хэлэлцлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс хуралдан 6 хүүхдийн хөгжлийн бэрхшээл, 5 хүүхдийн байнгын асаргааны хугацааг сунгаж ажиллалаа.

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Вирүст гепатитийн урьдчилан сэргийлэлт, илрүүлэг, оношилгоо, эмчилгээний чадавх сайжруулах” сэдэвт сургалтыг зохион байгуулан эрүүл мэндийн байгууллагуудын эмч, лаборант, халдвар хяналтын ажилтан 83 хүн оролцлоо. Сургалт “Азийн хөгжлийн банк”-ны санхүүжилтээр зохион байгуулагдсан бөгөөд сургалтыг мастер сургагч багш нарын баг удирдан, вирүст гепатитын талаар онол, дадлага хосолсон сургалт 3 хоног явагдлаа.

“Дэлхийн гар угаах өдөр” -ийг жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд энэ жил “Цэвэр гар- Эрүүл орчин” сэдвийн дор Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгтэй хамтран нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж 78 хүн оролцлоо. Тасагт хэвтэн эмчлүүлж байгаа 125 үйлчлүүлэгчдэд гар угаах дарааллыг зааж өгч, сурталчилгаа хийлээ. Мөн аймгийн төвийн 7 цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн 1006 хүүхдэд, I, IV сургуулийн дунд ангийн 538 сурагчдад сургалт, 9 сумын эрүүл мэндийн төвийн сургууль, цэцэрлэгийн 1990 хүүхдэд, 931 ард иргэдэд сургалт, 3558 хүнд сурталчилгаа хийлээ.

ЭХЭМҮТ-ийн тандалт судалгааны албаны баг 2019 оны 10 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд хүүхдийн өвчлөл, эндэгдэл, амьгүй төрөлт, эхийн ноцтой хүндрэлийн байдал болон нүд, өсвөр үеийнхний эрүүл мэндийн тандалтын тогтолцоонд дэмжлэгт хяналт хийн мэргэжил арга зүйгээр хангаж ажиллалаа.

Тархвар судлалын 42 дугаар долоо хоног буюу 2019 оны 10 дугаар сарын 21-ний байдлаар аймгийн хэмжээнд амбулаторийн 2341 үзлэгээс 141 буюу 6%-ийг

томуу, томуу төст өвчин эзэлж, өмнөх долоо хоногоос 3,1%-иар өссөн. Яаралтай тусламжийн 151 дуудлагын 12 буюу 7.9% нь томуу томуу төст өвчин гэж оношлогдсон байна. Томуугаар өвчлөгсдийн 94.3% нь 15, үүнээс 79.4%-ийг 4 хүртэлх насныхан эзэлж байна.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 358 дугаар тушаалын дагуу харьяа байгууллагуудад томуу, томуу төст өвчнөөс хүндрэлээс сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдахгүй шуурхай үзүүлж бэлэн байдлыг хангаж ажиллах талаар зөвлөмжийг хүргүүллээ.

Эрүүл мэндийн сайдын А/451 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг “Томуугаас сэргийлье” уриан дор зохион байгуулан ажиллаж эрүүл мэндийн байгууллагын 914 ажилтан, зорилтот бүлгийн 450 хүнийг тархвар судлалын заалтаар, сайн дурын үндсэн дээр 784 хүнийг томуугийн эсрэг вакцинаар тус бүр дархлаажуулаад байна.

Орон нутгийн төсвийн 20.0 сая төгрөгийн санхүүжилтээр “Аз жаргалын цэцэрлэгт хүрээлэн”-гийн тохижилтыг ажлыг Б.Батчимэг ахлагчтай иргэдийн бүлэг гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өглөө.

Нэгдсэн эмнэлгийн гэмтлийн тасагт тавилга тоног төхөөрөмж худалдан авах зардлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 30.0 сая төгрөг батлан тендер зарлагдаж “Голден мед” ХХК 24.2 сая төгрөгөөр 12 нэр төрлийн 20 ширхэг тавилга тоног төхөөрөмж нийлүүлж хүлээлгэн өглөө.

Бигэр, Цээл, Алтай, Төгрөг, Шарга сумдад сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, үзлэг шинжилгээг эмч, лаборант, рентген техникч, тандалтын багийн бүрэлдэхүүтэйгээр зохион байгуулан нийт 1417 хүнийг хамрууллаа. Нийт үзлэгээс 14-өөс дээш хоног ханиалгасан 89 хүн, цээжний рентген шинжилгээгээр өөрчлөлттэй 27 хүнийг илрүүлэн 2 удаагийн цэрний сорьц авлаа. Рентген шинжилгээ болон эмнэл зүйгээр сүрьеэгийн 5 тохиолдлыг илрүүлж сорьцыг баталгаажуулахаар ХӨСҮТ-рүү явууллаа.

Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс Өвөрхангай аймагт зохион байгуулсан “Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн оношилгоо, эмчилгээний сургалтын гарын авлага танилцуулах, сургагч багш бэлтгэх” 2 өдрийн сургалтанд нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн эмч 1, сувилагч 2, нийт 4 хүний бүрэлдэхүүнтэй хамрагдаж ирлээ.

2019-2020 оны хичээлийн жилд дээд мэргэжлийн эмч 15, дунд мэргэжилтэн 5, нийт 20 эмнэлгийн эмч, мэргэжилтэнг төрөлжсөн мэргэжлийн сургалтад төрийн сангийн санхүүжилтээр сургахаар гэрээ байгуулан явууллаа.

Эрүүл мэндийн газрын дарга, Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, хүүхдийн зөвлөх эмч нар Япон улсад туршлага судлах чиглэлээр, Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр Бээжин хотод Нэгдсэн эмнэлгийн дотрын их эмч зүрх судлалын чиглэлээр тус тус сургалтад хамрагдлаа.

ДОЛОО. БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГ, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Боловсрол, соёл урлагийн газар Онцгой байдлын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Дэлхийн зөн Олон улсын байгууллагатай хамтран аймгийн "Өсвөрийн аврагч" аварга баг шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгуулж,

Халиун, Есаенбулаг сумын 2, 3, ХЭЦ ерөнхий боловсролын сургуулиуд оролцож 3 дугаар сургуулийн баг аварга болж 10 дугаар сарын 20-нд улсын аваргын тэмцээнд орохоор боллоо.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар “Ирвэстэй нутгийн ирээдүй” төслийг Увс, Говь-Алтай, Баян-Өлгий аймгийн 11 сумд хэрэгжүүлэн боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд зорилтот бүс нутгийн сургуулийн багийг чадваржуулах 2 дахь шатны сургалтыг 2019.09.23-25-ны өдрүүдэд Увс аймагт зохион байгуулагдлаа. Сургалтад Баян-Уул, Жаргалан, Дарив, Шарга сумын ерөнхий боловсролын сургуулийн 8 багш, 4 сургалтын менежер, 2 мэргэжилтэн нийт 14 хүн оролцлоо. Сургалтаар орон нутгийн онцлогийг тусгасан сургуулийн хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан хойч ирээдүй болсон хүүхэд багачуудад орон нутагт нь тархан амьдарч байгаа нэн ховор амьтан болох Цоохор ирвэсийг таниулах, түүнийг хайрлан хамгаалахад оролцох арга ухаанд суралцуулах, тэдний оролцоог дэмжих Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг хэрэгжүүлэх ингэснээр тухайн бүс нутгийн иргэд байгалтайгаа харилцан шүтэлцэж амьдарч ирсэн уламжлал соёлоо сэргээн байгаль орчны доройтлыг зогсооход хувь нэмрээ оруулах юм.

Дэлхийн багш нарын 25, Монголын багш нарын 53 дахь өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ нь “Алтайн боловсролын форум” нэрийн дор зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээнд 11 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулагдаж эдгээрт 58 боловсролын байгууллага, давхардсан тоогоор 1100 багш оролцлоо.

Алтайн боловсролд инноваци хийх боломж, анги удирдах арга зүй эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа. Уг хуралд “Боловсрол дахь шинэчлэл” сэдвээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн С.Цагаанбаатар, “Боловсролын шинэчлэлийн тулгуур нь багш” сэдвээр Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн багш Ц.Сэвжид, “Шавийн ирээдүй багшийн гарт” сэдвээр Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтэн Ц.Чанцалдулам, “Сурагчдын анхаарлын төвлөрөлтийг химийн хичээлээр судлах нь” сэдвээр АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь сургуулийн багш Л.Нямаа, “Багш шавийн барилдлага” сэдвээр Есөнбулаг сумын 3 дугаар сургуулийн багш М.Сувданцэцэг, “Багшийн харилцаа” сэдвээр аймгийн Мал эмнэлгийн газрын албаны дарга Х.Сувд, “Багш миний нүдээр” сэдэвт илтгэлийг Есөнбулаг сумын 3 дугаар сургуулийн сурагч Э.Ширмэнтүяа тус тус оролцлоо.

Алтайн боловсролын инновацийн үзэсгэлэн-2019:

Инновацийн үзэсгэлэн анги удирдах арга зүйн шинэчлэл, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн “Үдийн цай” хөтөлбөрийн брэнд бүтээгдэхүүн Х-лаборатори-Ээлжит хичээлийн энгийн туршилтууд, хүүхдийн сэтгэхүй хөгжүүлэх арга технологи гэсэн дөрвөн чиглэлээр зохион байгуулагдаж, сургуулийн өмнөх боловсролын 12, ерөнхий боловсролын 27 сургууль 156 инновацийн бүтээлээр оролцоо.

Эдгээрээс шилдэг 15 бүтээлийг шалгаруулж, шилдэг бүтээлийн гэрчилгээ олголоо.

Анги удирдах арга зүйн шинэчлэл төрөлд:

-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургууль “Эх оронч үзэл төлөвшүүлэх цогц арга зүй”

-1 дүгээр сургуулийн “Анги удирдах арга багц”

-Есөнбулаг сумын 4 дүгээр цэцэрлэгийн “Бутармаг зүйлсийг ашиглан хүүхдийг массаар нь хөгжүүлэх арга зүй”

Хүүхдийн сэтгэхүй хөгжүүлэх инновац:

-Жаргалан сумын ерөнхий боловсролын сургуулийн “Зөв зөв” сэтгэхүй хөгжүүлэх тоглоом

-Есөнбулаг сумын 1 дүгээр сургуулийн “Анги удирдах 10 багц ажил”

-Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн “Оюуны нэг цэгийн үйлчилгээ”

Үдийн цайны брэнд:

-Баян-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цайны багц”

-Баянтоорой багийн ерөнхий боловсролын сургуулийн “Эко бүтээгдэхүүний багц”

-Тайшир сумын ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цайны багц бүтээгдэхүүн”

Х лаборатори-Ээлжит хичээлийн энгийн туршилт:

-Халиун сумын ерөнхий боловсролын сургуулийн “Хүүхдэд аюулгүй 18 багц туршилт”

-Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн “Энгийн туршилтын багц”

-Есөнбулаг сумын 4 дүгээр сургуулийн “Орон зайн баримжаа олгох багц туршилт”

Анги удирдах арга зүйн шинэчлэлийн үзүүлэх ажил:

Анги удирдах арга зүйн шинэчлэлийн үзүүлэх ажлаар Есөнбулаг сумын 1, 2, 3, 4 Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулиуд өөр өөрийн онцлогтой ажлуудыг 210 багшид зохион байгууллаа. Үүнд:

-1 дүгээр сургууль “Бага насны хүүхдийг массаар нь хөгжүүлэх арга зүй”

-2 дугаар сургууль “Төсөлд суурилан хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх арга зүй”

-3 дугаар сургууль “Сургуулийн олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх арга зүй”

-4 дүгээр сургууль “Бага насны хүүхдийн гадаад хэлний чадварыг хөгжүүлэх арга зүй”

-Хантайшир-Эрдэм цогцолбор сургууль “Бага насны хүүхдийн хөгжүүлэх арга зүй” сэдвээр үзүүлэх ажлуудыг тус тус зохин байгуулж, харилцан туршлага хуваалцлаа.

Багш-Эрдэнэ ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа:

Багшийн нэр хүндийг өсгөх, үнэлэмжийг нэмэгдүүлэх, урамшуулах зорилготой “Багш-Эрдэнэ-2019” ёслол хүндэтгэлийн арга хэмжээгээр 200 багшийг 34930.0

төгрөгөөр 13 байгууллагыг 31100.0 төгрөгөөр тус тус шагнаж урамшууллаа. Багш-Эрдэнэ ёслолын арга хэмжээнд боловсролын салбарын тусгай шилжүүлэг болон орон нутгийн төсвөөс 66030.0 төгрөгийг зарцуулсан байна.

Мөн гар бөмбөг, шагайн харваа, теннис, шатар гэсэн төрлөөр спортын тэмцээн уралдаан зохион байгуулж, эдгээрт 25 сургуулийн 710 багш хамрагдсан байна.

2019 оны “Багш нарын баяр”-ын үйл ажиллагаа нь боловсролын салбарын инноваци ба анги удирдах арга зүйн хүрээнд явагдаж багшид тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэн, шийдвэрлэж, харилцан туршлага солилцсоноороо онцлог байлаа.

Боловсролын салбарт хэрэгжиж буй Багшийн хөгжил, Сургалтын чанарыг ахиулах Оюунлаг-Алтай хөтөлбөрүүдийн үр дүнд дараах ахиц амжилтууд бий болжээ. Үүнд:

-Улсын хэмжээнд явагдсан Боловсролын чанарын үнэлгээний шалгалтад 21 аймгаас эхний 3 дугаар байрт, 667 сургуулиас Есөнбулаг 1 дүгээр ерөнхий боловсролын сургууль 9, Тонхил сумын ерөнхий боловсролын сургууль 18 дугаар байрт шалгарч “**TOP-20**” сургуульд багтлаа.

-Багшийн нийгмийн баталгааг хангах, нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх үүднээс “Багш-Эрдэнэ” ёслолын арга хэмжээг 2017 оноос хойш зохион байгуулж, улсын хэмжээнд амжилт гаргасан багш, боловсролын байгууллагуудыг урамшуулах ажилд улсын болон орон нутгийн төсвөөс 117 сая төгрөгийг гаргаж, 547 багшийг шагнаж урамшуулжээ.

-Аймгийн сургалтын чанарыг сайжруулах олон төрлийн арга хэмжээг авч ажилласны үр дүн өмнөх оныхоос 5.7 хувиар ахисан үзүүлэлттэй байна.

-Зөвлөх зэрэгтэй багшийн тоо 11-ээр нэмэгдэж, багшийн мэргэжлийн зэргийн чанарт ахиц гарсан.

-Багшийн онолын мэдлэг, ур чадвар сайжирч өмнөх оныхоос 8.1 хувиар өслөө.

-Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж үзүүлэлтээр улсад 9 дүгээр байрт шалгарч тогтмол амжилтыг үзүүллээ.

Хөвсгөл аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, лаборатори нэгдүгээр сургуулийн үйл ажиллагаатай танилцан туршлага судаллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэх, биеийн тамир спортыг нийтийн хүртээл болгох, аймгуудын багш нарын хамтын ажиллагааг хөгжүүлэх, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, арга туршлага солилцох зорилготой “ХӨДӨӨГИЙН БАГШ НАРЫН СПОРТЫН XVII НААДАМ”-ЫН тэмцээн 2019 оны 10 сарын 08-14-ний өдрүүдэд Хөвсгөл аймагт амжилттай зохион байгуулагдаж дүнгээ гаргалаа. Энэхүү тэмцээнд Говь-Алтай, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Орхон, Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Сэлэнгэ, Дорнод, Хөвсгөл, Завхан, Булган, Хэнтий, Архангай аймгуудын нийт 15 багийн 840 тамирчин хурд хүч, авхаалж самбаагаа сорин уралдаж оролцсоноос багийн дүнгээр 27,5 оноогоор Сэлэнгэ алтан медаль, 48 оноогоор Дархан-Уул мөнгөн медаль, 48,5 оноогоор Орхон хүрэл медаль тус тус эзэллээ. Говь-Алтай аймгийн баг тамирчид волейбол, сагсан бөмбөг, ширээний теннис, шагайн харваа, шатар гэсэн 5 төрлөөр 28 тамирчин

оролцож 57 оноогоор 10-р байранд орсон бөгөөд эмэгтэй волейболын төрөлд Х.Баянтуул ахлагчтай баг Говь-Алтай аймгийн багш нарын багийн спортын анхны хүрэл медалийг хүртсэн түүхэн амжилт үзүүллээ. Шатрын төрөлд Ч.Сэржмядаг 8-р байр, ширээний теннисний төрөлд Э.Алтайбаатар 7-р байрт шалгарсан амжилтуудыг үзүүллээ.

Биеийн тамир спортын чиглэлээр:

Прокурорын байгууллагын ажилчин албан хаагчдын дундах баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээн 10 дугаар сарын 4-5-ны өдрүүдэд болж өндөрлөлөө. Тус тэмцээнд баруун бүсийн 4 аймаг Ховд, Баян-Өлгий, Увс, Говь-Алтай аймгийн прокурорын байгууллагын баг тамирчид сагс, волейбол, шатар, 100 буудалт даам, ширээний теннис, снүкер билльярд гэсэн спортын 7 төрлөөр өрсөлдөж аваргуудаа тодрууллаа. Багийн нийлбэр дүнгээр нэгдүгээр байрт Ховд, хоёрдугаар байрт Говь-Алтай, гуравдугаарт байрыг Увс аймгийн баг тамирчид тус тус эзэллээ.

Иргэдийг нийтийн биеийн тамир, спортоор хичээлэх нөхцлийг бүрдүүлэн Биеийн тамир спортын газарт 2019-2020 онд Үндэсний бөх, Жү-до бөх, Чөлөөт бөх, Сагсан бөмбөг, Таеквондо, Самбо бөх, Волейбол, Шатар, Хөнгөн атлетик гэсэн 9 төрлөөр секц дугуйлан хичээлүүлж байна.

НАЙМ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

Аймгийн хэмжээнд 2019 оны 10 сарын байдлаар нийт 714 иргэн ажил хайгчаар бүртгэлтэй байгаа ба 465 нь эмэгтэй байна. Тайлант сард бүртгэлтэй ажил хайгч иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл 43% нь бүрэн дунд, 27 % нь дээд, 11% нь техникийн мэргэжлийн боловсролтой байна. Мөн бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны байдлаар нь авч үзвэл 33,3% нь 25-34 насны залуучууд, 15-24 насны залуучууд 24,7 %-ийг эзэлж байна.

Тайлант сард аймгийн хэмжээнд 22 иргэн ажлаасаа чөлөөлөгдөж, ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолт авсан байна.

Орон нутгийн нийгмийн түншлэлийн харилцааг бэхжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор ХНХЯам, Монголын ажил олгогч эздийн Холбоо, Үйлдвэрчний Эвлэлийн Холбооноос Баруун бүсийн зөвлөгөөнийг 2019.10-11-ны хооронд тус аймагт зохион байгуулалаа. Тус арга хэмжээнд аймгийн Засаг даргын орлогч, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, ХХҮГ-ын дарга, Аймгийн ажил олгогч Эздийн Холбоо, Үйлдвэрчний Эвлэл болон ажил олгогчийн төлөөлөл нийт 70 гаруй төлөөлөл оролцож, Хөдөлмөр нийгмийн зөвшөлийн 3 талт хэлэлцээрийг шинэчлэн баталлаа.

Гол нь аймгийн ажилгүйдэл ядуурлыг бууруулах, ажлын байр бий болгоход чиглэгдсэн 15-34 насны хүртлэх насны ажил идэвхитэй хайгч 15 залуучуудыг чадамжид суурьласан үе шаттай сургалтад хамрууллаа.

Орон нутгийн залуучуудын бизнес санааг дэмжих, тэднийг ажлын байраар хангах зорилгоор “Алтайн баялаг-Залуус” хөтөлбөрийн хүрээнд Startupweekend Gowi-

altaï хөтөлбөрийг 2019 оны 10 дүгээр сарын 13-14-ний өдрүүдэд аймгийн Засаг даргын тамгын газар, Төрөлх Алтай ТББ-тай хамтран зохион байгууллаа.

Хөтөлбөрийн зорилго нь аймагт залуучууд гарааны бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлэх, мөн орон нутгийн онцлог шинжийг агуулсан цахиур хагалсан бизнес санааг шинээр гаргаж ирэх, дэмжих, орон нутгийн залуучуудыг гарааны бизнес эрхлэх мэдлэг чадвартай, сэтгэхүйтэй болгоход чиглэгдсэн юм. Сургалт-арга хэмжээний 1-р шатны бүртгэлд нийт гарааны бизнес эрхлэх сонирхолтой 75 залуу бүртгүүлснээс 2-р шатанд 65 залуучууд шалгарч бизнес санаагаа уралдуулснаас дараах залуучуудын 14 бүлэг шалгарч хүүгүй 10 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 36 сарын хугацаатай эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олголоо.

Энэ сард нийгмийн халамжийн сангаас дараах тэтгэвэр тэтгэмжийн санхүүжилтийг хийлээ.

- Халамжийн тэтгэвэр 1308 иргэнд 226,6 сая.төг
- Нөхцөлт мөнгөн тэтгэмж 912 иргэнд 73,5 сая.төг
- Амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 195 иргэнд 31,8 сая.төг
- Ахмад настны хөнгөлөлт тусламж 100 иргэнд 13,5 сая.төг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж 81 иргэнд 6,6 сая.төг
- Жирэмсэн эхийн тэтгэмж 528 иргэнд 19,0 сая төгрөг

- Алдарт эхийн одонтой 4 эхэд 0,4 сая төгрөг

- Цалинтай эхийн тэтгэмж 2622 иргэнд 128,5 сая төгрөг
- Өрх толгойлсон эх эцэгт олгох тэтгэмж 2 иргэнд 0,6 сая төгрөг
- Алдар цолтой ахмадын хөнгөлөлт 32 иргэнд 6,4 сая.төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлсэн.

2019 оны түлшний үнийн хөнгөлөлт 50 ахмадад 7,0 сая, 241 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 33,7 сая төгрөг олголоо.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээнд харьяа 6 байгууллагын удирдлага арга зүйгээр хангаж ажиллаа.

Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын чиглэлээр:

Тайлант сард шинээр тэтгэвэр тогтоолгосон хүсэлт гаргасан сум, аймгийн төвийн өндөр настан-45 хүн, тахир дутуу-29 хүн, нийт 74 даатгуулагчийн тэтгэврийн баримт материалыг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Шинээр сайн дурын даатгалд-26 иргэн, Эрүүл мэндийн даатгалд-310 иргэнийг тус тус хамруулж 12403.7 мянган төгрөг хийлээ.

Тэтгэмж тогтоолт, олголтоор хөдөлмөрийн чадвар түр алдсан-43 хүнд 7316.5 мянган төгрөг, Жирэмсэн, амаржсаны-55 хүнд 88050.1 мянган төгрөг, Оршуулга-17 хүнд 17 сая төгрөг тогтоож олгосон байна.

Ажилгүйдэл шинээр-20 хүнд 29099.8 мянган төгрөг, Олгосон нь 47 хүнд 18348.6 мянган төгрөг байна.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар 218 хүн орж, үүнээс шинээр 39 хүн хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгож, 177 хүн сунгагдаж, 8 хүн буцлаа.

ЕС. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Өсвөр насны охидын гоо зүй, биеэ зөв авч явах соёл, ёс суртахууны хүмүүжил, эрүүл мэнд нөхөн үржихүйн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, бэлгийн хүчирхийллийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, тэдний өөрийгөө үнэлэх үнэлэмж, өөртөө итгэх итгэлийг нь дээшлүүлэх зорилгоор Охидын эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсоох зорилготой "ОХИДОО ХАЙРЛАЯ ХАМГААЛЪЯ" охидын аяныг 2019 оны 09 дүгээр сарын 16-аас 10 дугаар сарын 16-ыг хүртэлх хугацаанд амжилттай зохион байгууллаа.

“Охидоо хайрлая, хамгаалъя” аяны хүрээнд Хүүхдийн эрхийн конвенц батлагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан хүүхэд багачуудад “Хүүхдийн эрхийн конвенц”-ийг сурталчилах, таниулах зорилгоор Есөнбулаг сумын зургаан сургуулийн 120 сурагчийг хамруулан "Конвенци- 30" танин мэдэхүйн АХА тэмцээнийг АХНЗ-тэй хамтран зохион байгууллаа.

Өсвөр насны охидтой чин сэтгэлийн ярилцлага өрнүүлэн тэднийг аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, амьдралын зөв дадал хэвшил, биеэ зөв авч явах чадварт сургах, тулгамдаж буй асуудлыг нь сонсох, шийдвэрлэх арга замыг нь тодорхойлох, зөвлөн туслах зорилгоор нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн нөлөө бүхий хүмүүстэй уулзуулан, 10 дугаар сарын 14-ны өдөр МСҮТ, ерөнхий боловсролын сургуулиудын 8-12 дугаар ангийн 300 сурагчийг хамруулан “Охидтой ярилцах чин сэтгэлийн ярилцлага”-ыг аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлтэй хамтран зохион байгууллаа.

Аяны хугацаанд хүүхдүүдэд тулгамдаж байгаа асуудал, санал хүсэлтийг нь авах зорилгоор ерөнхий боловсролын 1, 2, 3, 4, 5 дугаар сургуулиудад сэтгэлийн хайрцаг аялуулж нийт 367 хүүхдийн санал хүсэлтийг авлаа.

“Цоохор ирвэс хамгаалах Олон улсын өдөр”-ийн хүрээнд Хүүхэд залуучуудын Мазаалай театр Ю.Санжаагончигийн зохиолоос сэдэвлэсэн “Цоохор найз” хүүхдийн жүжгийг Дэлхийн байгаль хамгаалах сан, Аймгийн Байгаль орчны газрын дэмжлэгтэйгээр 2019 оны 10 сарын 21-ны өдөр тоглолоо. Уг жүжгийг ОХУ-ын Тува, Алтайн БНУ, Баян-Өлгий, Ховд, Увс, Өмнөговь аймгийн Эко клубын багш сурагчид болон Дэлхийн байгаль хамгаалах сангийн төлөөлөл нийт 200 орчим хүн үзэж сонирхсон юм. Жүжгийн ерөнхий продюсер Т.Эрхэмбаяр, жүжгийн найруулагч А.Сарантуяа, хөгжмийн зохиолчоор Э.Хүрэлбаатар, тайз зураачаар Н.Пүрэвжал ажиллаа.

Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдсэн, авто тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодон саатуулагдсан 5 иргэнд хүмүүжлийн эерэг аргын талаар сургалт зохион байгууллаа.

Амьдрах ухаан ба өөртөө итгэх итгэл сэдвээр Монгол Ментор хөтөлбөрт сайн дураараа хамрагдсан 14 хүүхдийг чадавхижуулах амьдрах ухааны сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд оролцогчид өсвөр үе залуучуудад бие болон сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх нэгэн чухал ач

холбогдолтой болох мөн өөртөө итгэх итгэлээ тодорхойлж өөртөө итгэх итгэлийн суурь үндсийг бүрдүүлэх 4 хүчин зүйлсийг судалж мэдлээ.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийг хүүхэд залуучуудад таниулан мэдүүлэх, хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийн хүрээнд тухайн орон нутагт хүүхдийн эрхийн чиглэлээр гарсан ололт амжилтыг хэлэлцэх, орон нутгийн удирдлагууд хүүхдээ сонсож, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор Конвенци 30 арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Хүүхдийн эрхийн Конвенци нь Хүүхдийн эдлэх эрхүүдийг тунхагласан Олон улсын эрхзүйн баримт бичиг бөгөөд 1989 оны 11 сарын 20-ны өдөр батлагдсанаас хойш нэгдэж орсон 5 дахь улс нь Монгол Улс юм. Өнөө жил Хүүхдийн эрхийн Конвенцийн 30 жилийн ой болож байгаа бөгөөд энэ хүрээнд НҮБ-ийн Хүүхдийн Сангийн суурин төлөөлөгч болон мэргэжилтнүүд манай аймагт ажиллаа. Энэ ажлын хүрээнд Есөнбулаг сумын 6 сургуулийн 120 хүүхдүүдтэй, Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Халиун, НҮБ-ын Хүүхдийн Сангийн шадар суурин төлөөлөгч Спесиоз Хакизimana болон орон нутгийн шийдвэр гаргах түвшний хүмүүс чөлөөт уулзалт ярилцлага хийж хүүхдүүдийн үзэл бодол сонирхсон асуултад хариулсан юм.

Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, хохирогчийг хамгаалах, хүчирхийлэлд өртөгсдөд үйлчилгээ үзүүлэх чадавхийг бэхжүүлэх, мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааг уялдуулах зорилгоор “ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИАР ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” сургалтыг 2019 оны 10-р сарын 16, 17-ны өдрүүдэд Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтран зохион байгууллаа. Сургалтанд баг, сургуулийн нийгмийн ажилтан, цэцэрлэгийн арга зүйч, цагдаагийн албан хаагч, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нийт 30 албан хаагчдыг хамруулж мэдлэг арга зүйн чадвар олголоо.

Ирээдүйн эзэд сурагчдын мэргэжил сонголтын аяны хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн 11-р ангийн сурагчдад Мэргэжлээ хэрхэн зөв сонгох талаар лекц, Мөн Ерөнхий боловсролын сургуулийн 2,3,4 -р сургуулийн багш нарт Багш, эцэг эх, хүүхдийн хамтын ажиллагаа сэдэвт ангийн багшийг чадавхижуулах сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил хамгаалал, үйл ажиллагааны талаарх гарын авлага, боршур, зөвлөмж, ном товхимолыг иргэдэд 1200 ширхэгийг тарааж сурталчиллаа.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газраас өсвөр насны хүүхдүүдэд ирээдүйд эзэмших мэргэжлээ зөв сонгохтой холбоотой мэдээлэл өгөх, ахлах ангийн сурагчдад эрсдэлээс урьдчилан сэргийлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил сонголтод арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын үндэсний хэмжээний аяныг 3 дахь удаагаа зохион байгууллаа.

Үйл ажиллагаанд аймгийн “Нийгмийн ардчилал” МОХ-ны Ерөнхийлөгч Г.Батдорж, “Оюунлаг” клубын үүсгэн байгуулагч Н.Булгантамир, Залуу уран бүтээлч З.Ариунжаргал нар оролцож төгсөх ангийн сурагчдад өөрийгөө дайчлах, ялан дийлэх, мөрөөдөлдөө тэмүүлэх, мэргэжлээ зөв сонгох зэрэг сонирхолтой шилдэг илтгэл, лекцүүдийг хүргэлээ. Сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох нь тэдний амьдралын бодит баталгаа болохоос гадна Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн

тэнцвэрт байдал хангагдах хүчин зүйл болно. Энэ үеэр “Мэргэжлийн чиг баримжаа олгох” чиглэлээр мэргэшсэн зөвлөхүүд сурагчдад ганцаарчилсан зөвлөгөө өгч байгаа нь аяны үр дүнг нэмэгдүүлсэн юм. Уг үйл ажиллагаанд аймгийн төвийн 4 сургуулийн ЕБС-ийн ахлах ангийн сурагчид МСҮТ-ийн суралцагчид нийт 210 хүүхэд хамрагдлаа.

АРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Намрын “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг аймгийн Засаг даргын Тамгын газар Байгаль орчин аялал жуулчлалын газар, Есөнбулаг сумын ЗДТГ, Сум дундын ойн анги, Улаанбаатар дахь Нутгийн зөвлөлтэй хамтран 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Алтай хотод 5 дахь жилдээ зохион байгууллаа.

Есөнбулаг сумын Засаг даргын 1/370 дугаар албан бичгээр 64 аж ахуйн нэгж, албан байгууллагуудад мод тарих, модны нүх ухах хуваарь хүргүүлж, Солонго хороололд 26 байгууллагын 486 ажилтан алба хаагчид 896 нүх ухах бэлтгэн, 2000 улиас, хайлаас, Хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэнд 22 байгууллагын 408 ажилтан алба хаагчид оролцож, 896 модны нүх ухах бэлтгэн 1600 улиас, Нисэх, Баарангийн давааны чиглэлд 15 байгууллагын 149 ажилтан, алба хаагчид оролцож 500 улиас МСҮТ-ийн хамт олон хашаандаа 500 улиас, нийт намрын мод тарих өдрийн хүрээнд 64 албан байгууллагын 1113 ажилтан алба хаагчид оролцож, 2574 модны нүх ухах бэлтгүүлэн 4600 улиас, хайлаас тарьлаа. Мод тарих хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж байгууллага, сумдад нутгийн зөвлөлөөс 1000 суулгац үнэгүй тарааж тариуллаа. Мод тарихад 48 м3 элс, 48 м3 бор шороо, 16 м3 бууц татаж бэлтгэлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Дэлхийн аялал жуулчлалын өдөр, Монгол Улсад аялал жуулчлалын салбар үүсч хөгжсөний 65 жилийг ойг тохиолдуулан салбарын хэмжээнд сурталчлах, таниулах, хөгжүүлэх чиглэлээр үе шаттай ажлуудыг зохион байгуулж байгаа бөгөөд аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газрын аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг Улаанбаатар хотод 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдөр "Аялал жуулчлалын маркетинг, сурталчилгаа" сэдэвт семинар, 10 дугаар сарын 03-07-ны өдрүүдэд Манжуур хотод "Туршлага судлах, техник аялал"-ын хөтөлбөрт хамрууллаа.

Нэн ховор болон ховор амьтдыг төлөөлүүлэн говийн гайхамшигт 6 амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, амьдрах орчныг сайжруулах зорилгоор "Говийн гайхамшигт-6" зөвлөгөөнийг Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын санаачилгаар жил бүр уламжлан зохион байгуулдаг. 2019 оны 10 дугаар сарын 6-8-ны өдрүүдэд Говийн гайхамшигт-6 дөрөвдүгээр уулзалт, зөвлөгөөн Хустайн нурууны байгалийн цогцолбор газарт зохион байгуулагдаж тус газрын дарга Д.Батмагнай, мэргэжилтэн Г.Олонбаатар, Б.Содмаа нар оролцлоо.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын "Ирвэстэй нутгийн ирээдүй" төслөөс санаачлан "Экологид ээлтэй мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь" бүсийн зөвлөгөөнийг 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Алтай хотод зохион байгуулж буй бөгөөд тус газрын мэргэжилтэн Б.Содмаа, Д.Мөнгөнчимэг нар оролцлоо.

Монгол Улсын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газрын ахлах байцаагч Ч.Эрдэнэбаяраар ахлуулсан ажлын хэсэг 2019 оны 10 дугаар сарын 24-25-ны

өдрүүдэд манай аймагт ажиллаж 10 дугаар сарын 25-нд "Оюуны өмчийн тухай ойлголт", "Аж үйлдвэрийн өмчийн тухай ойлголт", "Аж үйлдвэрийн өмчийн мэдүүлгийн системийн хайлт, ашиглалт", "Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, тулгамдаж буй асуудлууд сэдвээр төрийн албан хаагчид, аймгийн жижиг, дунд бизнес эрхлэгчид, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга, Засаг дарга, иргэд олон нийтийг хамруулсан сургалт зохион байгуулж тус газрын мэргэжилтэн М.Наранцацрал хамрагдлаа.

Тус газраас "Газар нутгийг тусгай хамгаалалтад авах хэрэгцээ" уулзалт хэлэлцүүлгийг "Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь" төсөлтэй хамтран 2019 оны 10 сарын 30-ны өдөр БОАЖГ-т төсөл хэрэгжиж буй Цогт, Эрдэнэ, Чандмань сумын төлөөлөл 25 хүнийг оролцуулан зохион байгууллаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Швейцарийн элчин сайдын яамны Хамтын ажиллагааны газрын дэмжлэгтэйгээр Есөнбулаг сумын нутагт орчны бохирдол, хүнд металл болон мөнгөн усны бохирдлын судалгааны ажлыг 8 дугаар сард Эко трейд ХХК-аар гүйцэтгүүлсэн бөгөөд дүнг танилцуулах уулзалт тус газарт 10 дугаар сарын 14-нд зохион байгуулагдаж холбогдох байгууллагын мэргэжилтнүүд оролцоо. Мөн 10 дугаар сарын 15-нд ЗДТГ-т холбогдох байгууллагын дарга нарт судалгааны ажлыг дүнг танилцуулан зөвлөмж хүргүүлээ. Дүн танилцуулах уулзалтын дараагаар тус газраас холбогдох албан байгууллагууд руу аймгийн "Мөнгөн ус, хүнд металаар бохирдсон газруудад авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"- ий төсөлд санал авах албан бичгийг хүргүүлж саналыг нэгтгэн БОАЖЯ-д хүргүүлээ.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын "Ирвэстэй нутгийн ирээдүй" төсөлтэй хамтран 10 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд Алтай хотод "Цоохорын цоглог найзууд" сэдвийн дор Ирвэсийн фестиваль-2019 арга хэмжээг Монгол Улсын Ирвэстэй 5 аймаг болох Ховд, Баян-Өлгий, Увс, Өмнөговь, Говь-Алтай аймаг, ОХУ-ын Тува болон Алтайн Бүгд найрамдах Улсын эко клубын 200 гаруй сурагч, албаны төлөөлөгчдийг оролцуулан зохион байгууллаа.

Тус газраас байгаль орчин, аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчилах, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн зураглалын баталгаажуулалт хийх, байгаль хамгаалагчдын ажлыг шалгах зэрэг ажлуудаар сумдад 3 хэсэг болон 2019 оны 10 дугаар сарын 28-аас эхлэн ажиллаж байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон Улсын 30 дахь өдрийг тохиолдуулан Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд даргын 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Онцгой байдлын газар, аймгийн Засаг даргын Тамгын газар, Улаан загалмай хороотой хамтран "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг 10 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын баатар М.Жанчивын талбайд зохион байгууллаа.
/Зураг 1-2/

6.

7. Зураг 1-2 Нээлттэй хаалганы өдөрлөг аймгийн төв талбай

8.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү нарын хамтран баталсан удирдамж, аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/524

дүгээр захирамжийн дагуу аймгийн хэмжээнд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудад 10 дугаар сарын 14-17-ны хооронд улсын үзлэг зохион байгууллаа.

Улсын үзлэгт Дэлгэр сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг “Мандал-Алтай” группын “Хөв булаг” нүүрсний уурхай, Бигэр сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг “Эн си жи ти” ХХК-ий алтны уурхай, “Марка поло” ХХК-ий алтны болон бусад ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа явуулдаг, Цээл сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг “Алтайн хүдэр” ХХК-ий төмрийн хүдрийн уурхайнууд хамрагдав. /Зураг 3-6/

9. *Зураг 3-4 Үзлэг шалгалт зохион байгуулж байгаа нь*

10.

11. *Зураг 5-6 Үзлэг шалгалт зохион байгуулж байгаа нь*

12.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/437 дугаар тушаалаар баталсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу 10 сарын 23-ны өдөр алба хаагчдад “Эх оронч үзэл, Цэрэг эх оронч хүмүүжил” сэдвээр газрын дарга, дэд хурандаа З.Баттулга, “eoffice” программын талаар Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн н.Бямбадорж нар сургалтыг зохион байгууллаа.

Шатны сургалтын талаар:

Өдөр тутмын дасгал сургуулийг аврах уяаг зангидах, түгшүүрийн дохиогоор тавиунгаас гарах, хөдөлмөр хамгааллын хувцас өмсөх дасгал, гал унтраах тархалт, аврах уяаг зангидаж, нэрвэгдэгсдэд углах, аврах олсыг хундган эвхэлтээр эвхэх, тасгийн гал унтраах тархалт, гурав сунадаг шатыг автомашинаас авч гуравдугаар давхарт байрлуулах гэсэн төрлүүдээр төлөвлөгөө гарган 31 удаа 217 алба хаагчдад дасгал сургууль хийлгэсэн.

Гал унтраах тархалтын сургуулийг 3 дугаар цэцэрлэг, 4 дүгээр цэцэрлэг, 2 дугаар цэцэрлэг, 7 дугаар цэцэрлэгт зохион байгуулсан. Сургалтад 54 ажилтан, гал түймэр унтраах, аврах 59 дүгээр ангийн 16 алба хаагч 3 нэгж техник хэрэгсэл оролцсон. /Зураг 9-10/

13. *Зураг 9-10 Танхимын сургалт*

14.

Ангийн бие бүрэлдэхүүний 3 шатны сургалт бэлтгэл, бэлэн байдал цэрэгжилч жагсаалч ажиллагааг сайжруулж, дүрэмт хувцсыг зөрчилгүй цэвэр хэрэглүүлэх чиглэлээр 7 хоног бүрийн 1, 3 дахь өдөр хувцасны үзлэг хийж, 10 дугаар сард хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг дүгнэсэн. /Зураг 11-12/

15. *Зураг 11-12 Салааны захирагч нарын ажлыг дүгнэж байгаа нь*

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баттайваны 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу Онцгой байдлын газраас төрийн байгууллагуудын үйл ажиллагааг иргэдэд сурталчилах “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээнд 10 дугаар сарын 22-ны өдрийн 10:00 цагаас 16:00 цагийн хооронд оролцсон.

Уг арга хэмжээнд хүрэлцэн ирсэн иргэд, үйлчлүүлэгч нараас байгууллагын талаар сэтгэл ханамжийн судалгаа авч, иргэн бүрт Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуулиудын иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эрх, хүлээх үүргийг хэвлэн 250 хүнд тараасан. Мөн аюулт үзэгдлийн төрлүүдээр бэлтгэсэн бэлэн бай гарын авлага тараах материалыг 500 ширхэгийг тарааж байгууллагаа иргэдэд сурталчилсан./Зураг 13-14/

16. Зураг 13-14 Нээлттэй хаалганы өдөрлөг

Гамшгаас урьдчилан сэргийлэх тухай мэдээ мэдээллийг иргэдийн гар утсанд мессеж илгээн ажилласан. Мөн аймгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах өдрийг тохиолдуулан талбай дээр байгууллагын багаж техник, тараах материал, өгч ажилласан.

10 дугаар сард галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Есөнбулаг сумын Жаргалант, Түмэн, Оргил, Харзат багийн нийт 830 айл өрх, баар, ресторан, караокены чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд, уул уурхайн компаниудын 20 объект, дүгнэлт авахыг хүссэн 11 байгууллагыг хамруулан үзлэг шалгалт хийж 376 зөрчил илрүүлснээс 160 зөрчлийг шалгалтын явцад арилгуулан, 216 зөрчлийг арилгуулахаар хугацаатай мэдэгдэл 8, албан шаардлага 6 бичиж, холбогдох газруудад хүргүүлэн биелэлтэд нь хяналт тавьж зөрчлийг арилгууллаа.

АРВАН НЭГ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Говь-Алтай аймгийн Мэргэжлийн Хяналтын Газар, Автотээврийн Үндэсний төв, Төрийн өмчит үйлчилгээний газар, Аймгийн Автотээврийн төв хамтран Алтай хотод авто үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдэд Авто тээврийн тухай хуулийн холбогдох заалтууд, авто үйлчилгээ, ангилал, ерөнхий шаардлага MNS5025-2010 стандарт, тохирлын гэрчилгээ олгох журам, авто үйлчилгээний ангилал тогтоох журмаас мэдээлэл хийн ярилцлага зохион байгуулж, гарын авлага материалаар хангаж нийт 26 хүн оролцов.

“2019-2020 оны өвөлжөөлтийн бэлтгэлийг хангасан байдал, цаашид авах арга хэмжээ”-ний талаар “Мандал-Алтай групп” ХХК, “Мандал голомт” ХХК-иудын удирдлага, ИТА-нуудтай ярилцлага зохион байгуулан ажиллав.

“Мандал-Алтай групп” ХХК-ийн Хөв булгийн уурхай нь 130 орчим мян.м3 хөрс хуулж, 37 орчим мян.тн нүүрс авахад бэлэн болгож, 400тн нүүрс цагаалсан байна.

Цаашид нүүрсний олборлолтыг нэмэгдүүлж, хогт хольцоос нь салгаж, “Мандал голомт” ХХК-ийн дулааны зуухнуудыг шигшсэн нүүрсээр хангах, уурын зуухнуудын яндангийн шүүлтүүрийг 2019 оны 12-р сарын 01-ны дотор шинэчлэн солих, Алтай хотын хог хаягдлын төвлөрсөн цэгт уурын зуухны үнсийг 14 хоногийн Бямба гариг бүр ачуулах зэрэг үүрэг, даалгаврыг өглөө.

“Мандал Голомт ХХК”-ийн 1,2-р нэгдсэн халаалтын зуухандаа буцламтгай үед ажиллах зуух нөөцөнд суурилагдахаар төлөвлөж байна.

Шинэ сум төслийн хүрээнд Дэлгэр сумд хийгдэж байгаа барилга угсралтын ажлын үеийн аюулгүй ажиллагааг хангаж, илэрсэн зөрчлийг 2019 оны 11-р сарын 01-ний дотор бүрэн арилгах үүрэг даалгавар өгч ажиллав.

Аймгийн хэмжээнд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин баригдаж байгаа 13 барилга, байгууламжийн угсралтын ажил хийгдэж,

гүйцэтгэл дунджаар 90%-тай, Дарив, Цогт сумын Эрүүл мэндийн төв, Эрдэнэ сумын ЗДТГ-ын барилга ашиглалтад орсон байна.

“Тайшир-Алтай” ус хангамжийн төслийн хүрээнд 14.0 сая еврогийн санхүүжилттэй 54.8 км урттай цэвэр усны шугамын барилга угсралтын ажил хийгдэхээс ажил 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 27 км шугамын барилга угсралтын ажил хийгдэж, гүйцэтгэл 50%-тай байна.

Хоёр. Боловсрол, соёл, эрүүл мэнд, хүнсний чанар, эрүүл ахуйн бодлогын хүрээнд:

Мал эмнэлэг, хүнсний эрүүл ахуйн хяналтаар:

Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдөр баталсан удирдамжийн хүрээнд Есөнбулаг сумын Индэрт, Харзат багуудад байрлалтай “Алтайн сүрлэг нуруу” ХХК-ий “Түмэн-Уул”, “Хүрийн-Овоо” ХХК-ий мал төхөөрөх, мах эхлэн боловсруулах үйлдвэрүүд, “Наяд натур” ХХК-ий мал төхөөрөх цехийн үйл ажиллагаанд 2019 оны 10 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд хамтарсан хяналт шалгалт хийж гүйцэтгэв.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага өгч ажиллав.

МХЕГ-аас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа мал төхөөрөх, мах эхлэн боловсруулах 3 үйлдвэр болон мал эмнэлгийн үйлчилгээний 59 нэгж нийт 62 объектод эрсдэлийн үнэлгээ хийж ажиллав. “Шинэ-Алтай” ХХК-ий худалдааны төвд ажиллаж байгаа махны худалдаалалтад эрсдэлийн үнэлгээ хийгдэж байна.

Орчны эрүүл ахуйн хяналтаар:

“Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-т ундны усны эх үүсвэр, ус түгээх байруудын хамгаалалтыг сайжруулах, ард иргэдэд мэдээлэл хийж ажиллах талаар албан тоот хүргүүлэн, Алтай радиод 1, Миний нутаг телевизэд 1 удаа ундны усны шинжилгээний дүнгийн талаар мэдээлэл хийв.

Эрдэнэ, Чандмань сумдын Эрүүл мэндийн төв, Энх-Алтай, Жаргалан-Алтай өрхийн эрүүл мэндийн төв, Эрүүл-Ирээдүй хувийн эмнэлгийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж хэрэгжүүлэв. Улсын байцаагчдын өгсөн албан шаардлагын биелэлт хангалтгүй байсан тул Зөрчлийн тухай хуулийн дагуу 2-р албан тушаалтанд нийт 1.0 сая төгрөгийн шийтгэвэрийн арга хэмжээ авч ажиллав.

Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтаар:

Шинэ-Алтай худалдааны төвийн гурил зардаг 23 иргэнд ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний хадгалалтын талаар сургалт зохион байгуулж ажиллалаа.

Мал үржлийн хяналтаар:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 01/453 дугаар удирдамжийн дагуу Говь-Алтай аймгийн хэмжээд зонхилон үржүүлж буй үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсэг, омгийн бог малын хээлтүүлэгчийн хянан баталгаажилт нь “Малын генетик нөөцийн тухай” хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаад 6 сумын бог малын хээлтүүлэгчийн хянан баталгаажуулалтын байдалд хяналт хийж, танилцуулга, дүн

мэдээг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын газарт хүргүүлэв.

Шалгуулагч объектийн 2019 оны эрсдэлийн үнэлгээ хийх зорилгоор 8 сумын 2734 малчин өрх болон туслах аж ахуй эрхлэгчдээс судалгаа авав.

Хүүхдийн эрүүл ахуйн хяналтаар:

Эрдэнэ, Чандмань сумдын цэцэрлэг, Чандмань сургуульд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийв. Шалгалтаар гүйцэтгэлийн шалгалт хангалтгүй хэрэгжүүлсэн Чандмань сумын цэцэрлэгт 500.000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ ногдуулав. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Есөнбулаг сумын 8 дугаар цэцэрлэгт гүйцэтгэлийн хяналт шалгалт хийв. Үр дүнд Хамтарсан 39 заалттай албан шаардлага өгснөөс 9 заалтыг биелүүлсэн. Хөрөнгийн асуудлаас шалтгаалан зарим зөрчлүүдийг арилгаагүй байна.

Эм биобэлдмэлийн хяналтаар:

Эмийн сангуудад Монгол улсын эмийн жагсаалтад бүртгэлгүй, бүртгэлийн загвараас зөрүүтэй, хэрэглээний хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгсэл худалдаалсан, жороор олгох эмийг жоргүй олгосон эсэхт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж зөрчил гаргасан 6 эмийн санд 4.550.0 мянган төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ авч ажиллалаа.

Гурав. Байгаль орчин, уул уурхай, хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгаалал, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

Геологи уул уурхайн хяналтаар:

Ашигт малтмалын хууль бусаар олборлох эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 01/76 тоот удирдамжийн хүрээнд хийж танилцуулж МХЕГ-т хүргүүлж ажиллав. Үр дүнд хууль бусаар газрын хэвлий ашиглаж байсан 1 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авч, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан 2 баяжуулах цех, 1 иргэнийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 1.0 сая төгрөгний нөхөн төлбөр, 2.8 сая төгрөгний шийтгэвэр ноогдуулан ажилласан байна.

Байгаль орчин хяналтаар:

МХЕГ-ын даргын баталсан 2019 оны 02/75, 01/98, 01/26 тоот удирдамжуудын хүрээнд хийгдсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, шинжилгээний хяналт, тандан судалгааны үр дүн, танилцуулгын МХЕГ-т хүргүүлэв. Хяналт шалгалтын хүрээнд 7 зөрчил илрүүлж 4.820.000 төгрөгийн нөхөн төлбөр, 1.200.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллав.

Гүйцэтгэлийн хяналтаар 22 аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалтыг хийхэд эрсдэл 31-49% -аар буурч, хуулийн хэрэгжилт 21-29%-аар өссөн байна.

Аймгийн хэмжээгээр үйлдвэрлэл, үйлчилгээнд ус ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын худаг уст цэгийн тоолууржуулалт, усны төлбөрийн барагдуулалтын байдалд сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч нартай хамтран хяналт шалгалт хийгдэж байна.

Газар, геодези зураг зүйн хяналтаар:

2019 оны төлөвлөгөөт хяналт шалгалтыг 30 аж ахуйн нэгж, байгууллагад хийж, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 21 аж ахуйн нэгж, байгууллагуудад хийж ажилласны үр дүнд эрсдэл 21.9-30.5%-аар буурч, хуулийн хэрэгжилт 19-23%-аар өссөн байна.

Нийгмийн хамгаалалын хяналтаар:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 1/221 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийн дагуу 2018 оны 09 дүгээр сарын 04-өөс 10 дугаар сарын 01-ий хооронд Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын 2018 оны сүүл, 2019 оны эхний хагас жилийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт хийж, Их цалуу ББСБ ХХК-аар 2 ажилтны нийгмийн даатгалын шимтгэл 2307.8 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоож, ХХҮХ-т шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 6 заалттай, аймгийн Засаг даргад 1 заалттай улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж ажиллав.

Эрчим хүчний хяналтаар:

“Алтай-Улиастай Эрчим Хүчний Систем” ТӨХК-д төлөвлөгөөт хяналт шалгалт хийж гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийн хяналт шалгалт хийгдэж байна.

МХЕГ-аас ирүүлсэн 01/81 дугаартай удирдамжийн дагуу хангагч “Дашваанжил” ХХК, 12 хэрэглэгчийг хамруулж урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж үр дүнд ашиглалтын хугацаа дууссан хийн баллонд цэнэглэлт хийгдэхээ больсон.

МХЕГ-аас ирүүлсэн 01/55 дугаартай удирдамжийн дагуу Алтай хотын төвд байрлах нэгдсэн болон хэсэгчилсэн халаалтын 15 зууханд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 1 объектод 500.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ ноогдуулж ажиллав. Танилцуулгыг хавсралт хүснэгтийн хамт МХЕГ-ын Дэд бүтцийн газарт хүргүүлж ажилласан.

Хөдөлмөрийн хяналтаар:

“Уран охид” ХХК-ийн барилга угсралтын талбайд ажиллаж байсан ажилтан осолдож гэмтсэн мэдээллийн дагуу үйлдвэрлэлийн ослын акт баталгаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэн, тус компанийн холбогдох албан тушаалтнуудад сургалт хийж, албан шаардлага хүргүүлэн ажиллав.

Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яамны сайдын тушаалаар баталсан “Уул уурхайн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”-ын улсын үзлэгийг аймгийн Засаг даргын А/254 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг 4 хоногийн хугацаанд 3 сумын 12 аж ахуйн нэгжийг хамруулан зохион байгуулж, тухайн салбарт гарч болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж хэрхэн хэрэгжиж байгаатай газар дээр нь танилцаж, мэдээлэл судалгаа хийж, дүн мэдээг нэгтгэн ажиллав.

МХЕГ-аас ирүүлсэн 01/40 дугаар удирдамжийн хүрээнд “Шинээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа”-нд урьдчилан сэргийлэх шалгалтыг хийж, танилцуулгыг холбогдох газарт хүргүүлэн ажиллав.

Төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан 20 аж ахуйн нэгжийн 11-д нь буюу 55%, төлөвлөгөөт бус шалгалтад хамрагдсан 2 аж ахуйн нэгж буюу 100%-д нь нийт 13 аж

ахуйн нэгжид гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж ажилласны үр дүнд эрсдэлийн түвшин 6%-аар буурч, хуулийн хэрэгжилт 12%-аар өссөн дүнтэй байна.

Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтаар :

МХЕГ-аас ирүүлсэн 01/92 дугаартай удирдамжийн хүрээнд “ Хил орчмын нутаг дэвсгэрийн хөрсөнд хөрсөнд цацрагийн хяналт шалгалт хийж, танилцуулгыг холбогдох газарт хүргүүлэн ажиллав.

МХЕГ-аас ирүүлсэн 01/80 дугаартай удирдамжийн хүрээнд “Тусгай зөвшөөрөлгүй цацрагийн үүсгүүрийг илрүүлэх” урьдчилан сэргийлэх шалгалт хийж, танилцуулгыг холбогдох газарт хүргүүлэн ажиллав.

Төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан 17 аж ахуйн нэгжийн 11-д нь буюу 64.5%, төлөвлөгөөт бус шалгалтад хамрагдсан 2 аж ахуйн нэгж буюу 100%-д нь нийт 13 аж ахуйн нэгжид гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж ажилласны үр дүнд эрсдэлийн түвшин 15% байснаас 5%-аар буурч, хуулийн хэрэгжилт 41.1% байснаас 13%-аар өссөн дүнтэй байна.

Хэмжилзүйн хяналтаар:

МХЕГ-аас ирүүлсэн 01/69 тоот удирдамжийн дагуу цэвэр усыг хууль бусаар олборлон, үйлдвэрлэлд ашиглаж буй аж ахуй нэгжүүдийг илрүүлэх, гарч буй зөрчлийг арилгуулах, цэвэр усны хэрэглээний төлбөр тооцооны хэмжлийн үнэн зөв байдалд урьдчилсан сэргийлэх хяналтыг 13 аж ахуй нэгж хамруулан хийж Шалгалтаар нийт 20 зөрчил илрүүлэн шалгалтын явцад 9 буюу 45%-ийг арилгуулаж 3 аж ахуй нэгжийн гүний худгийг тоолууржуулан ажиллав.

2019 оны төлөвлөгөөт хяналт шалгалтуудыг 100% хийж гүйцэтгэсэн ба 5 объектод гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийж ажилласны үр дүнд эрсдэлийн түвшин 10 %-аар буурч хуулийн хэрэгжилт 15%-аар өссөн үр дүн гарав.

Авто замын хяналтаар:

Алтай-Ховд, Алтай–Баянхонгор чиглэлийн автозамуудад хийгдсэн засварын ажлын чанарт гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, хяналт шалгалтын дүн, танилцуулгыг фото зургаар баталгаажуулан МХЕГ-т хүргүүлж ажиллав. Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа Алтай хотын төвийн 3 км хатуу хучилттай авто замын ажлын чанарт өгөгдсөн Албан шаардлагын мөрөөр гүйцэтгэлийн хяналт шалгалтыг гүйцэтгэж, цаг агаар хүйтэрч байгаатай холбогдуулан 2019 оны 10-р сарын 28-ны өдрөөс эхлэн хучилтын ажлыг зогсоох талаар захиалагчид албан тоот хүргүүлж ажиллав.

Тус аймагт 2019 оны 10-р сарын 18-19-ны өдрүүдэд их хэмжээний цас орж зам даваа хаагдсантай холбогдуулан Алтай-Ховд чиглэлийн авто замд Аймгийн Онцгой байдлын газартай хамтарсан хяналт шалгалт хийж, Баарангийн давааны 8 км авто замын цасыг цэвэрлүүлж, улсын байцаагчийн дүгнэлт үйлдэж холбогдох газарт хүргүүлж ажиллав.

Алтай хотын төвд баригдаж байгаа 3 км хатуу хучилттай авто замын угсралтын ажид урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг гүйцэтгэж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 5 заалт бүхий хугацаатай албан шаардлага үйлдэж ажиллав. Орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа хотын төвийн хатуу хучилттай

авто замын засвар, Дөтийн давааны 12 км хайрган хучилттай авто замын засварын ажлын чанарт төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Дөрөв. Нэгдсэн лаборатори:

Лабораторид 7 байгууллага 14 аж ахуйн нэгжээс ирүүлсэн 130 сорьцод 419 үзүүлэлтээр хими, хор судлал, нян судлал, хорио цээрийн шинжилгээ хийхэд унд ахуйн усны 11 сорьц 18 үзүүлэлтээр/стандартаас магнийн хатуулаг 2 – 195 - аар, нийт хатуулаг 14-өөр, нянгийн тоо 36 - аар их/, агаарын 4 сорьц 4 үзүүлэлтээр / нянгийн тоо стандартаас 92 – 1250 - аар их/, шүүлтүүрийн усны 2 сорьц 2 үзүүлэлтээр /нянгийн тоо стандартаас 97 – 116 - аар их/, шар манжингийн 1 сорьцын 1 үзүүлэлтээр /нитрит 400 – аар их/стандартын шаардлага хангаагүй.

Шинжилгээний төлбөрийн төвлөрүүлэлт 157.0 мянган төгрөг буюу 100%-тай байна.

Тав. Бургастайн хилийн Экспорт, импорт хил хорио

цээрийн хяналтын хэлтэс

Бургастайн Орох чиглэлд: Монгол Улсын хилээр 11 тээврийн хэрэгсэл орж ирснээс Монгол улсын тээврийн хэрэгсэл 11 байна. Зорчигчдын тухайд 25 зорчигч орж ирснээс Монгол улсын иргэн 23, гадаадын иргэн 2 байна.

Бургастайн Гарах чиглэлд: Монгол Улсын хилээр 11 тээврийн хэрэгсэл гарснаас Монгол улсын тээврийн хэрэгсэл 11 байна. Зорчигчдын тухайд 25 зорчигч гарснаас Монгол улсын иргэн 23, гадаадын иргэн 2 байна.

Тус боомтоор “Бүрдмэл-Алтай” аж ахуй нэгж 270.0 тн нүүрсийг импортоор оруулж ирсэн байна.

АРВАН ХОЁР. СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ТАЛААР:

Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургууль 10-р сард “Ирвэстэй нутгийн ирээдүй” төслийн хүрээнд “Ирвэс хамгаалах аян”-ыг зохион байгууллаа. Аяны хүрээнд анги бүхэн ирвэсийн талаарх сонин хачин, түүний хамгаалалттай холбоотой мэдээ мэдээллээс бүрдсэн ханын сонин гаргаж Урлаг зааланд үзэсгэлэн хэлбэрээр байршуулан хүүхэд, эцэг эх, иргэдэд сурталчиллаа. Нийт 24 бүлгийн 24 ханын сонин гарсныг 500 хүүхэд, 76 багш, ажилтан, 150 гаруй эцэг эх, иргэд үзэж сонирхлоо.

Бигэр сумд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 25 сая төгрөгийн санхүүжилтээр хийгдэж буй 5-р багт шинэ хөв барих, сумын ОНХ Сангийн 9 сая төгрөгийн хөрөнгөөр хуучин хөвийг сэргээн засварлах ажлуудыг “Хэмжээлшгүй од” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж ажлын явцтай танилцан албан шаардлага, зөвлөмж хүргүүлээ.

Чандмань сумд 320 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн хичээлийн байрын өргөтгөлийг 2.2 тэрбум төгрөгийн өртөгөөр “Топ фасед монголиа компани” барьж энэ хичээлийн жилийн 2-р улирлаас шинэ сургуульдаа хичээллэж эхэллээ.

Дэлгэр сумын ЗДТН Энх тайвны корпусын сайн дурын мэргэжилтэн Эмилигийн төслийн хүрээнд 1-5-р ангийн нийт 80 сурагчдад “Шүд” “Хорт зуршил” зэрэг сургалтуудыг 2 өдрийн турш зохион байгууллаа.

Эрдэнэ сумын ЗДТГ Хууль тогтоомжийг сурталчлах ажлын төлөвлөгөөний дагуу Цэцэг нуур, Сангийн далай, Цагаан уул багийн 190 гаруй иргэнд хөдөлмөр халамж, “Цэвэр орчин-Эрүүл Алтай” аян, хадлан тэжээл бэлтгэх талаар мэдээлэл хийсэн байна.

Есөнбулаг сумын ЗДТГ “Төрөлх-Алтай ТББ”, Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран “Хавдаргүй-Алтай” урьдчилан сэргийлэх үзлэгт 800 гаруй иргэнийг хамруулж, томуугийн дархлаажуулалтанд 75 хүүхэд, 27 иргэнийг хамрууллаа.

Төрөлх-Алтай ТББ-тай хамтран зорилтот өрхийн 70 хүүхдийн шүдийг эмчилж эрүүлжүүллээ.

Шарга сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Өрмөн шаргал говь-2019” үзэсгэлэн худалдаа энэ жил 11 дэх жилдээ амжилттай зохион байгуулагдлаа. Энэ удаагийн үзэсгэлэн худалдаа гар урлал, цагаан идээ, хүнсний ногоо гэсэн төрлөөр явагдаж 25 үйлдвэрлэгч 2-26 нэр төрлийн бүтээгдэхүүнээр тус тус оролцож шилдгүүдээ шалгарууллаа.

Тайшир сум жил бүр уламжлал болгон “Нэг өрх-Нэг бүтээгдэхүүн - 2019” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж 3 багийн нийт – 27 иргэн, 3 аж ахуйн нэгж, оролцож 9 номинациар шалгаруулан зохион байгуулалт сайтай, оролцоо сайтай шилдэг багаар Галуут баг шалгарсан байна.

Цээл сумын Эрүүл мэндийн төв “Цагаан идээний үзэсгэлэн” худалдааны үеэр “Шүдэнд ээлтэй-Хүнс” арга хэмжээ зохион байгуулж, шалгарсан иргэнийг 200000 төгрөгөөр шагнаж урамшуулсан байна.